

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ  
*/2012 он/***

Өлгий хот 2013 он

## Гарчиг

1.Ойлголт тодорхойлолт, судалгааны товч агуулга	4
2.Суурин хүн амын насны бүтэц ажил эрхлэлт	7
3.Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны үзүүлэлтүүд	8
4. Баруун бүсийн үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт	11
5.Хөдөлмөрийн чадваргүй хүн ам, суралцагчид	12
6.Ажиллагчид, ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд	14
7.Ажилгүйчүүд, ажилгүйдлийн түвшин	17
8.Шинэ ажлын байр, бүтэц, сумаар	19
9.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт	20
10.Дүгнэлт	22



Танилцуулгыг хянан, тохиосон:

Х.Бахыт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Ш.Манзелхан

---

---

Санал хүсэлт байвал доорх  
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс  
Засаг даргын тамгын газрын байр

Е-mail: [stat-bel@mongol.net](mailto:stat-bel@mongol.net)

Утас: 70422432 , 70422322

Интернет хаяг: //www.nso.mn/bayan-ulgii/

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс  
Өлгий хот, 2013 оны 06-р сар

## **Танилцуулгад орсон үзүүлэлтүүдийн ойлголт, тодорхойлолт, тооцсон аргачлал**

**Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам** – Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилна.

Эдийн засгийн идэвхитэй хүн амыг урт хугацаагаар буюу хуанлийн жилээр хэмжигдэх байнгын идэвхитэй хүн ам, нэг долоо хоног буюу нэг өдрийн хугацаагаар хэмжигдэх тухайн үеийн идэвхитэй хүн ам гэсэн хоёр аргаар тодорхойлдог. Энд орсон ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам нь “байнгын идэвхи” гэсэн ойлголтонд тулгуурласан ба нөгөө талаар Монгол Улсын хуулиар тогтоосон хөдөлмөрийн насны хүрээнд багтах хүн ам тул 2000 оны хүн ам, орон сууцны тооллого, 2002-2003 болон 2006-2007 оны Ажиллах хүчний түүвэр судалгааны үед хэрэглэсэн “тухайн үеийн идэвхи”-ээр тодорхойлсон эдийн засгийн идэвхитэй хүн амаас зөрүүтэй учир тоо нь өөр өөр байгаа болно.

Хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй хүмүүс, хөдөлмөрийн насны суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол хүмүүс ажиллах хүчинд хамрагдаагүй болно.

**Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

Аж ахуйн нэгж, байгууллагын орон тоонд ажиллагч, албан бус хөдөлмөр эрхлэгч, гэрээгээр ажил гүйцэтгэгч, улирлын чанартай ажиллагчид, түр ажилтан, бүрэн бус цагаар ажиллагчид мөн ажилтай мөртлөө тодорхой шалтгаанаар (өвчтэй, чөлөөтэй, амралттай г.м.) ажиллаагүй хүмүүс хамрагдсан.

**Ажилгүйчүүд буюу ажилгүй иргэн** – Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн насны, хөдөлмөрлөх чадвартай, тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

-“ажилгүй байсан” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

-“ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

- “ажил идэвхтэй хайж байгаа” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл

авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

2000 оны хүн ам, орон сууцны тооллого, 2002-2003 болон 2006-2007 оны Ажиллах хүчний түүвэр судалгааны ажилгүйчүүдийн ойлголтонд тухайн долоо хоногт ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн, ажил хайж байгаа, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй болон бүртгэлгүй гэж хариулсан 15, түүнээс дээш насны бүх хүн хамрагдсан тул энд дурьдсан бүртгэлтэй, хөдөлмөрийн насны ажилгүй хүн амаас ялгаатай болно.

**Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин** – Ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан хувь.

**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин** – Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулсан хувь.

**Ажилгүйдлийн түвшин** - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхитэй хүн амд харьцуулсан хувь.

**Бүртгэлтэй ажилгүйчүүдийн хувь**- Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулна.

**Хүн ам зүйн ачаалал** – Хөдөлмөрийн насны нэг хүн амд ногдох хөдөлмөрийн насанд хүрээгүй, хөдөлмөрийн нас хэтэрсэн хүний тоо

**Хөдөлмөр эрхлээгүй хүн ам** – Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин, хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй г.м) шалтгаанаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн ам. Гэхдээ эдгээрт бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүмүүс ороогүй.

**Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам** – Хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрмөсөн алдсан нь тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүс.

**Хөдөлмөрийн насны суралцагчид** –Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай их, дээд сургууль, коллеж, тусгай мэргэжлийн анхан болон дунд шатны сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, 6 сараас дээш хугацаагаар мэргэжлийн сургалтанд хамрагдагчид, ЕБС-д суралцаж буй иргэд орно. Орой ба эчнээгээр суралцагчид, 6 сараас доош хугацаагаар суралцаж байгаа ажиллагчид нь тухайн байгууллагынхаа ажиллагчдын тоонд ордог тул тэдгээрийг суралцагчдад оруулахгүй.

## Оршил

Хүн амын ажил эрхлэлтийн судалгааны үзүүлэлтүүдийг сум, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа (Монгол Улсын харьяат, манай улсад удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын болон цагаач иргэд) суурин хүн амаар гаргадаг.

Энэхүү судалгаанд аймгийн нийт хүн амын чухам хэдэн хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид, ажилгүйчүүд, ажил эрхлээгүй хүн амын тоо хэд байгаа, хүн ам зүйн ачаалал, ажиллах хүчний хөдөлмөр оролцоо, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин ямар байгааг харуулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн өгөөжийг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч байна. Энэ жилээс эхлэн улсын хэмжээгээр ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг ажил эрхлэлтийн судалгааны үр дүнгээр тооцож байгаа болохоор зарим үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт урьд жилүүдийнхээс хэлбэлзэлтэй гарсан болно. Гэхдээ аймгийн түвшинд урьдийн адилаар Хөдөлмөрийн нөөцийн тайлангаар дотоод мэдээлэлээр, хураангуй үзүүлэлтээр авч байгаа болохоор зарим үзүүлэлтүүд аймаг бүсийн түвшинд ялгаатай гарч байгаа нь судалгаанаас харагдаж байна.

## Судалгааны товч агуулга

Энэ судалгааны гол зорилго нь эдийн засгийн идэвхитэй хүн амыг тодорхойлж, түүнээс ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин, ажил эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшинг тооцож зэрэгцүүлэхэд оршино. Эдгээр үзүүлэлтүүдийг аймгийн түвшин, сумдаар гаргасан. Мөн судалгаанд эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй болон ажил хөдөлмөр эрхлээгүй хүн ам, насны бүлгээр нь гаргаж харууллаа.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал нь ажиллах хүчний урсгал хөдөлгөөн ихтэй, ажиллагсдын бүтээмж бага, хөдөлмөрийн үнэлэмж доогуур, хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар хангалтгүй, ажилгүйчүүдийн дунд мэргэжлийн хүмүүсийн хувь хэмжээ их байгаа зэрэг сөрөг асуудлууд их байна.

Аливаа улс орны эдийн засгийн хөгжил, иргэдийнх нь аж байдал, амьжиргааны ерөнхий түвшин нь хүн амынхаа ажил эрхлэлтийн түвшинтэй зохих ёсоор холбоотой байдаг. Өндөр боловсролтой, ур чадвартай ажиллах хүч бол тухайн улс орны хөгжлийг тодорхойлогч нэгэн гол хүчин зүйл. Тухайн орны ажиллах хүч, ажил эрхлэлтийн байдал нь хүн амын насны бүтцээс шууд хамааралтай байдаг. Жил бүр хөдөлмөрийн насанд шилжиж байгаа хүний тоо, хөдөлмөрийн наснаас гарч байгаа хүний тооны зөрүү нь хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүний цэвэр өсөлтийг харуулна. Хөдөлмөрийн насанд шилжих хүний тоо нь тайлант жилээс 15 жилийн өмнөх төрөлтийн түвшин, нялхсын болон хүүхдийн нас баралтын түвшингээс хамаардаг билээ.

Аймгийнхаа суурин хүн амын бүтцийг 2008-2011 оны байдлаар авч үзвэл 16 хүртэлх насны хүүхдийн дунд эзлэх хувийн жин аажмаар буурч, харин хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь 2.4-ээр нэмэгдэж өндөр настаны эзлэх хувь 0.1-ээр буурсан байна. (Хүснэгт 1)

## Хүснэгт 1

## Суурин хүн амын насны бүтэц

	2008	2009	2010	2011	2012	өсөлт, бууралт				Нийт хүн амд эзлэх хувь				
						2012	2012	2012	2012	2008	2009	2010	2011	2012
						2008	2009	2010	2011					
Суурин хүн ам- Бүгд	93931	93017	89191	89374	88952	94.7	95.6	99.7	99.5	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үүнээс:16 хүртэлх настай	36025	34698	32804	32336	31980	88.8	92.2	97.5	98.9	38.4	37.3	36.8	36.2	36.0
Хөдөлмөрийн насны /16-59 настай /	53133	53589	51846	52604	52505	98.8	98.0	101.3	99.8	56.6	57.6	58.1	58.9	59.0
Хөдөлмөрийн нас хэтэрсэн / 60 ба дээш настай /	4773	4730	4541	4434	4467	93.6	94.4	98.4	100.7	5.1	5.1	5.1	5.0	5.0

Манай аймгийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь 16 хүртэлх насны хүүхдийн хувийн жин өсөхөд харин 1980,1990-ээд оны хүн амын өсөлт өндөр байсан үеийн залуучууд хөдөлмөрийн насанд дэвшин орсноор хөдөлмөрийн насны хүн амын хувийн жин өсөхөд нөлөөлжээ.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2012 онд 2008 оныхоос 0,1 хувь, 2009 оныхоос 1,8 хувь, 2011 оныхоос 0,2 хувиар буурсан нь шилжих хөдөлгөөнд тухайн насныхан ахиу орж байгаатай холбоотой байна. 2012 онд 2010 онтой харьцуулахад 1,3 хувиар нэмэгдсэн байна. Тоон үзүүлэлтүүд нь буурсан боловч суурин хүн амын дотор хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь буураагүй байна. Хөдөлмөрийн насны хүн амын тоо суурин хүн амын тооноос өсөлтийн хурд нь илүү байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын /16-59 нас/ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

## Хүснэгт 2

## Хүн амын ажил эрхлэлт

	2008	2009	2010	2011	2012	өсөлт бууралт			
						2012	2012	2012	2012
						2008	2009	2010	2011
Хөдөлмөрийн насны хүн ам	53133	53589	51846	52604	52505	98.8	98.0	101.3	99.8
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	33790	33893	30468	31477	30568	90.5	90.2	100.3	97.1
Ажиллагчид	32617	32601	29328	29877	29526	90.5	90.6	100.7	98.8
Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд	1173	1292	1140	1600	1042	88.8	80.7	91.4	65.1
Ажил эрхлээгүй хүн ам	9216	8903	10800	12816	8256	89.6	92.7	76.4	64.4
Хөдөлмөрийн насны суралцагчид	6403	6643	6521	5988	5559	86.8	83.7	85.2	92.8
Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин %	63.6	63.2	58.8	59.8	58.2	91.5	92.1	99.0	97.4
Ажил эрхлэлтийн түвшин (%)	61.4	60.8	56.6	56.8	56.2	91.6	92.4	99.4	99.0
Ажилгүйдлийн түвшин** (%)	3.5	3.8	3.7	5.1	3.4	98.2	89.4	91.1	67.1

2012 оны байдлаар өмнөх жилийнхээс хөдөлмөрийн насны хүн ам 0,2 хувиар, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам 2,9 хувиар, бүртгэлтэй ажилгүйчүүд 34,9 хувиар, ажил эрхлээгүй хүн 35,6 хувиар буурсан нь хөдөөнөөс аймгийн төв рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэж байгаатай холбоотой бөгөөд, хөдөлмөрийн насны суралцагчдын тоо 7,2 хувиар буурч, ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин 2,6 хувиар, ажил эрхлэлтийн түвшин 1,0 хувиар буурсан нь, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудад бүртгэлтэй ажигүйчүүдээр тооцсон ажилгүйдлийн түвшин 32,9 хувиар буурсантай холбоотой байна.

Хүснэгт 3

## Хүн ам зүйн ачаалал

	2000	2005	2008	2009	2010	2011	2012
0-15 насны хүн ам	39494	35836	33655	34698	32804	32336	31980
Хөдөлмөрийн насны хүн ам	50789	56548	55503	53589	51846	52604	52505
Өндөр настаны тоо	3811	3374	4773	4730	4541	4434	4467
Хүн ам зүйн ачаалал	<b>0.85</b>	<b>0.69</b>	<b>0.69</b>	<b>0.74</b>	<b>0.72</b>	<b>0.70</b>	<b>0.69</b>

Улс орнууд хүн амынхаа хөгжлийн ирээдүйн хандлагыг урьдчилан тодорхойлохдоо хүн ам зүйн ачааллыг харгалзан үздэг. Манай аймагт хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны нэг хүнд ногдох тэжээлгэгч хүний тооны харьцаа 2005 онд 0,69 байсан боловч жил дараалан ачаалал нэмэгдсээр 2012 онд 0,69 болж 2011 оныхоос 0,01 пунктээр буурсан байна.

Хүснэгт 4

## Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин / сумаар /

Сумын нэр	2008	2009	2010	2011	2012	өсөлт, бууралт			
						2012 2008	2012 2009	2012 2010	2012 2011
Алтай	79.8	78.4	81.1	84.5	82.1	102.9	104.7	101.2	97.2
Алтанцөгц	68.0	68.4	78.0	79.3	62.6	92.0	91.5	80.2	78.9
Баяннуур	64.5	70.9	75.1	76.5	57.1	88.5	80.5	76.0	74.6
Бугат	66.3	67.2	78.7	77.0	66.6	100.4	99.1	84.6	86.5
Булган	63.8	66.0	66.5	69.8	62.3	97.6	94.3	93.6	89.2
Буянт	64.4	68.6	69.0	70.7	68.9	106.9	100.4	99.8	97.4
Дэлүүн	84.4	79.9	89.4	89.3	56.4	66.9	70.6	63.1	63.2
Ногооннуур	82.7	82.9	86.4	89.5	80.8	97.7	97.5	93.6	90.3
Сагсай	82.5	84.0	90.1	90.7	74.9	90.7	89.1	83.1	82.5
Толбо	81.9	75.5	81.7	80.9	75.3	91.9	99.7	92.2	93.1
Улаанхус	79.3	72.4	88.6	77.8	73.4	92.6	101.4	82.9	94.4
Цэнгэл	84.3	83.2	81.1	83.6	82.8	98.2	99.5	102.1	99.0
Өлгий	38.0	39.0	37.4	35.9	36.7	96.6	94.1	98.2	102.3
Цагааннуур	44.8	46.3	49.3	48.2	44.5	99.3	96.1	90.3	92.3
Дүн	63.6	63.2	65.4	64.4	58.2	91.5	92.1	89.0	90.4



Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхитэй байдлыг харуулдаг гол үзүүлэлт болох ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшин 2011 онд 64.4 хувь байсан бол 2012 онд 58,2 болж 6,2 пунктээр буурсан байна. 2012 оны байдлаар ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшинг сумаар авч үзвэл Цэнгэл, Алтай, Ногооннуур,Толбо сумдад хамгийн өндөр буюу 82,8-75,3 хувьтай, Өлгий сум, Цагааннуур тосгон, Баяннуур, Дэлүүн сумдад хамгийн бага буюу 36,7-56,4 хувьтай байна. Ажиллах хүчний хөдөлмөр оролцооны түвшинг сүүлийн жилүүдтэй зэрэгцүүлэхэд 2012 онд 2008 оныхоос 8,5 хувиар, 2009 оныхоос 7,9 хувиар, 2010 оныхоос 11,0 хувиар,өнгөрсөн оноос 9,6 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 5


**Эдийн засгийн идэвхгүй хүн ам / хүйс, насны бүлэг, байршлаар /**  
*/ 2012 оны ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /*

		Бүгд			Хот			Хөдөө		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд		11658	5023	6635	5765	2362	3402	5893	2661	3233
Нас	15 - 19	5030	2588	2441	2426	1207	1219	2604	1381	1223
	20 - 24	913	341	572	677	193	483	236	148	88
	25 - 29	243	94	150	191	94	97	53		53
	30 - 34	48		48	48		48			
	35 - 39	193	96	97	94	46	48	99	50	50
	40 - 44	201	48	154	149	48	102	52		52
	45 - 49	438	99	339	288	48	239	150	50	100
	50 - 54	802	313	489	489	151	338	312	162	150
	55 - 59	979	495	484	572	286	286	407	209	198
	60 - 64	721	192	529	242	50	193	478	142	336
	65 - 69	634	143	491	148	50	98	487	94	393
70 +	1456	615	841	441	189	251	1015	426	589	

Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр хөдөлмөр эрхлээгүй хүний тоо 11658 болж, 56,9 хувийг эмэгтэйчүүд эзлэж байгаагийн 51,3 хувь нь хот суурин газарт, 48,7 хувь нь хөдөө амьдардаг эмэгтэйчүүд байна. 15-19 насныхан хөдөлмөр эрхлээгүй хүн амын 43,1 хувийг эзлэж байна.Улсын хэмжээний хөдөлмөр эрхлээгүй хүний 12,3 хувийг Баян-Өлгий аймаг эзлээд байна.

Зураг 1

**Эдийн засгийн идэвхгүй хүн амын насны бүтэц / хувиар /**




Хүснэгт 6

**Эдийн засгийн идэвхгүй хүн ам / хүйс, шалтгаан, байршлаар /**  
*/ 2012 оны ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /*

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хот			Хөдөө		
				Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Гэрийн ажилтай	492	191	301	194	97	97	298	94	204
Суралцдаг	5460	2646	2814	2908	1304	1604	2552	1342	1210
Тэтгэвэрт	2155	781	1374	971	347	624	1184	434	750
Өндөр настан	1352	427	925	345	94	252	1007	333	674
Хөгжлийн бэрхшээлтэй	1509	826	682	959	475	485	549	352	198
Ажил хийхийг хүсээгүй	47	47		47	47				
Хүүхэд асарсан	198		198	146		146	53		53
Өвчтэй байсан	342	50	292	148		148	195	50	145
Өвчтөн, өндөр настан асарсан	103	56	47	47		47	56	56	
Бүгд	11658	5023	6635	5765	2362	3402	5893	2661	3233

Зураг 2

**Эдийн засгийн идэвхгүй хүн амын бүтэц /хувиар/**



Судалгааны үр дүнгээр гарсан хөдөлмөр эрхлээгүй хүн амын дийлэнх хувь нь /47,0/ суралцагчид, /18,0/ тэтгэвэртэн, /13,0/ хөгжлийн бэрхшээлтэй иргэд, /12,0/ өндөр настангууд байна. Хот суурин газрын хөдөлмөр эрхлээгүй хүн амын 59,0 хувийг эмэгтэйчүүд, хөдөөгийн хөдөлмөр эрхлээгүй хүн амын 54,9 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Хүснэгт 7

**Баруун бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлтийн зарим  
үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт**

Баруун бүсийн аймгууд	Ажил эрхлэлтийн түвшин					Хөдөлмөр эрхлээгүй хүний тоо				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Баян-Өлгий	61.4	91.6	97.2	92.9	87.6	9216	3653	1231	3160	11658
Увс	73.7	92.2	85.0	89.1	91.6	4534	3277	2803	2952	10347
Ховд	66.8	90.4	90.8	81.8	92.0	4277	3940	5784	6693	15802
Говь-Алтай	72.5	93.5	91.0	89.7	86.3	3025	1939	5787	4225	7164
Завхан	73.3	96.0	85.1	91.3	93.6	4696	1322	3309	3279	18317
<b>Улсын дундаж</b>	<b>61.7</b>	<b>88.4</b>	<b>90.1</b>	<b>92.3</b>	<b>91.8</b>	<b>267489</b>	<b>131618</b>	<b>113438</b>	<b>87030</b>	<b>94705</b>

Судалгааны үр дүнгээр тооцож гаргасан бүсийн болон улсын дүнгийн тоо мэдээлэлүүд нь аймгийн сумаар гаргасан тооноос ялгаатай байгаа. Баруун бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлээгүй хүний тоогоор хамгийн өндөр нь Завхан аймаг, дараа нь Ховд, Увс, аймгууд орж байна. Говь-Алтай аймаг хөдөлмөр эрхлээгүй хүний тоогоор хамгийн багад орсон бол ажил эрхлэлтийн түвшингээр Завхан аймаг хамгийн өндөрт ороод байна.

Хүснэгт 8

**Ажилгүйдлийн үзүүлэлтүүд**  
*/ 2012 оны ажиллах хүчний судалгааны үр дүнгээр /*

Аймаг	Ажилгүйдлийн түвшин					Ажилгүйчүүдийн тоо				
	2008	2009	2010	2011	2012	2008	2009	2010	2011	2012
Баян-Өлгий	3.5	8.4	2.8	7.0	12.4	1173	1292	1140	1038	6389
Говь-Алтай	3.9	6.6	9.0	10.8	13.7	984	996	817	787	4183
Завхан	4.2	4.0	14.8	18.2	6.4	1526	2225	2651	1457	2547
Увс	4.2	7.8	15.0	10.4	8.4	1404	2252	1230	781	3177
Ховд	1.8	9.6	9.2	8.6	8.0	638	1121	1320	2132	2994
Баруун бус	3.5	7.5	10.1	10.8	9.8	5725	7886	7158	6195	19290
Улсад	2.8	11.5	9.9	7.7	8.2	29813	38077	38250	57171	94705


2012 оны байдлаар баруун бүсийн аймгуудаас хамгийн их ажилгүйчүүдтэй аймаг манай аймаг, хамгийн бага ажилгүйчүүдтэй аймаг Завхан аймаг байна. Баруун бүсийн ажилгүйчүүдийн 33,1 хувийг, улсын хэмжээний нийт ажилгүйчүүдийн 6,7 хувийг эзэлж байна.

2012 оны ажиллах хүчний судалгааны үр дүнгээр тооцсон ажилгүйчүүдийн тоо 6389 байгаагийн 44,0 хувийг мэргэжил, дадлага, туршлагагүйн улмаас ажилгүй байгаа иргэд, 43,0 хувийг мэргэжилд тохирох ажил олохгүй байгаа иргэд, 5,0 хувийг улирлын чанартай ажил эрхлэгчид эзэлж байна. Мэргэжилд тохирох ажил олохгүй байгаа болон мэргэжил, дадлага, туршлагагүйн улмаас ажилгүй байгаа иргэдийн эзлэх хувийн жин өндөр байгаа нь тухайн онд онд ЕБС-ийн 9,11 дүгээр анги төгссөн ажил, сургуульгүй үлдсэн хүүхдүүдийн өнөөгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд

нийцсэн ажлын байртай мэргэжил олгох болон мэргэшлийн ур чадварын сургалтанд хамрагдалт хангалтгүй, мөн ажлын байр хомс илүүдэлтэй мэргэжилийн чиглэлээр боловсрол эзэмшигчид их байгааг харуулж байна. (Зураг 3)

Зураг 3

**Ажилгүй иргэдийн бүтэц / шалтгаанаар /**



Хүснэгт 9

**Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүний тоо**

Он	Хөдөлмөрийн чадваргүй - Бүгд	2012 онтой харьцуулсан хувь
2008 он	3796	89.4
2009 он	4396	77.2
2010 он	4324	78.5
2011 он	3267	103.9
2012 он	3393	-

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүний тоо 2012 онд 3393 болж 2011 оныхоос 3,8 хувь буюу 126 хүнээр нэмэгджээ. (Хүснэгт 7).

Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн амд хөдөлмөрийн насны, албан ёсны эрх бүхий байгууллагын нотолгоогоор хөдөлмөрийн чадвараа 6 сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан нь тогтоогдсон хөгжлийн бэрхшээлтэй болон холбогдох хуулийн дагуу тэтгэврийн наснаасаа өмнө тэтгэвэр тогтоолгосон (тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүн орохгүй) хүмүүсийг хамруулсан.


Хүснэгт 10

**Хөдөлмөрийн насны суралцагчдын бүтэц**

	2008	2009	2010	2011	2012	2012 / 2011	Бүтэц				
							2008	2009	2010	2011	2012
Эрэгтэй	2800	2694	2977	2714	2532	93.3	43.7	40.6	45.7	45.3	45.5
Эмэгтэй	3603	3949	3544	3274	3027	92.5	56.3	59.4	54.3	54.7	54.5
Бүгд	6403	6643	6521	5988	5559	92.8	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4

## Хөдөлмөрийн насны суралцагчдын бүтэц хүйсээр / хувиар /



Хөдөлмөрийн насны суралцагчид 2009 онд 6643 байсан бол 2010 онд 6521, 2011 онд 5988, 2012 онд 5559 болж, 7,2 хувь буюу 429 хүнээр буурсан байна. Нийт суралцагчдын 45,5 хувийг эрэгтэйчүүд эзэлж өмнөх оныхоос 0,2 пунктээр буурсан байна. Ажил эрхлэлтийн түвшин 2012 онд 96,6 болж, 2011 оны хэмжээнд байна.

## Хүснэгт 11

## Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин /сумаар /

Сумын нэр	2008	2009	2010	2011	2012	өсөлт, бууралт			
						2012 2008	2012 2009	2012 2010	2012 2011
Алтай	76.7	76.6	81.2	97.2	97.4	127.0	127.1	120.0	100.2
Алтанцөгц	65.6	66.0	56.3	94.0	95.8	146.0	145.2	170.1	101.9
Баяннуур	63.3	69.8	67.9	94.5	96.2	152.0	137.8	141.6	101.8
Бугат	65.0	65.6	63.0	97.4	98.2	151.1	149.8	155.9	100.9
Булган	62.2	64.7	58.7	96.3	97.7	157.1	151.0	166.4	101.4
Буянт	62.9	66.8	68.1	97.5	98.0	155.8	146.8	144.0	100.6
Дэлүүн	83.1	78.5	62.7	96.0	96.9	116.5	123.4	154.5	100.9
Ногооннуур	81.7	82.0	78.1	97.3	97.9	119.9	119.4	125.4	100.6
Сагсай	81.7	83.0	76.8	95.7	97.3	119.0	117.1	126.6	101.7
Толбо	79.5	74.1	75.1	96.1	97.2	122.3	131.2	129.4	101.1
Улаанхус	78.7	71.8	77.1	98.1	99.0	125.8	137.9	128.4	100.9
Цэнгэл	83.1	82.0	68.3	97.9	98.3	118.3	119.9	143.9	100.5
Өлгий	34.2	34.4	33.2	96.7	93.1	272.1	270.6	280.5	96.3
Цагааннуур	40.6	41.0	49.1	89.6	92.3	227.0	224.8	188.0	103.0
Аймгийн дүн	62.2	76.6	56.6	96.6	96.6	155.2	126.0	170.7	99.9

Аймгийн төвд зөвхөн хөдөлмөрийн насны 3 хүний нэг нь ямар нэгэн ажил хөдөлмөр эрхэлдэг байна. Манай аймагт хөдөлмөрийн насны хүн амын 56,2 хувь нь албан ба албан бус хөдөлмөр эрхэлж, 15,7 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, 2,0 хувь нь бүртгэлтэй ажилгүйчүүд, 10,6 хувь нь суралцагчид, 6,5 хувь нь хөдөлмөрийн

чадваргүй иргэд байна. Ажил эрхэлдэггүй 8256 хүн ам байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын 15,7 хувийг эзэлдэг. Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүн ам 6,5 хувийг эзэлдэг. Өөрөөр хэлбэл хүүхэд, өндөр настангуудыг оролцуулаад ажил эрхэлдэг нэг хүн 3 хүнийг тэжээж байна.

Нийт ажиллагсдын 62,6 хувийг хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад, 11,6 хувийг боловсролын салбарт ажиллагсад, 7,3 хувийг бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, 4,5 хувийг төр захиргаа батлан хамгаалахын салбарт ажиллагсад 3,6 хувийг эрүүл мэндийн салбарын ажиллагсад, 2,0 хувийг тээвэр, холбооны салбарын ажиллагсад, 1,8 хувийг боловсруулах салбарын ажиллагсад, 1,3 хувийг барилгын салбарын ажиллагсад, 1,0 хувийг санхүүгийн байгууллагын ажиллагсад тус тус эзэлж байна.

Ажиллагчдын тоо 2012 онд 29526 болж, өмнөх онтой харьцуулахад 1,2 хувь буюу 351 хүнээр буурсан байна.

Хүснэгт 12


### Ажиллагсад эдийн засгийн салбарын ангиллаар

Эдийн засгийн салбарууд	2008	2009	2010	2011	2012	<u>2012</u> <u>2011</u>
ХАА,ан агнуур, ойн аж ахуй	22202	21363	18428	18895	18480	97.8
Загас агнуур	11	11	11	11	11	100.0
Уул уурхай	183	189	177	168	249	148.2
Боловсруулах үйлдвэр	538	557	569	567	546	96.3
Цахилгаан , дулааны эрчим хүч	284	291	297	302	317	105.0
Барилга	491	410	365	409	390	95.4
Бөөний ба жижиглэн худалдаа	2018	2332	2249	2311	2169	93.9
Зочид буудал, зоогийн газар	204	209	220	220	220	100.0
Тээвэр агуулах , холбоо	529	569	545	542	602	111.1
Санхүүгийн байгууллага	249	232	266	271	286	105.5
Үл хөдлөх хөрөнгө бизнес,түрээс	110	126	123	101	120	118.8
Төрийн захиргаа , батлан хамгаалах	1424	1431	1461	1462	1338	91.5
Боловсрол	3008	3109	3283	3318	3417	103.0
Эрүүл мэнд	977	1049	1036	1045	1075	102.9
НАА,нийгэм, хүн амын үйлчилгээ	333	232	231	202	255	126.2
Олон улсын байгууллагын, Хөлсний ажилчинтай өрхийн аж ахуй	56	51	67	53	51	96.2
Дүн	32617	32161	29328	29877	29526	98.8

Ажиллагсдын тоо 2012 онд 2008 оныхоос 9,5 хувиар, 2009 оныхоос 8,2 хувиар, 2010 оныхоос 0,6 хувиар тус тус буурч, 2010 оныхоос 0,7 хувиар нэмэгдсэн байна. Ажиллагсдын тоог эдийн засгийн салбаруудаар өмнөх онтой харьцуулаж үзэхэд цахилгаан, дулаан эрчим хүчний салбарт ажиллагсад 5,0 хувиар, уул уурхайн салбарт ажиллагсад 48,2 хувиар, тээвэр, холбооны салбарт ажиллагсад 11,1 хувиар, үл хөдлөх хөрөнгө бизнес, түрээсийн салбарт ажиллагсад 18,8 хувиар, боловсролын салбарт ажиллагсад 3,0 хувиар, эрүүл мэндийн салбарт ажиллагсад 2,9 хувиар, хүн ам, нийгэм үйлчилгээний салбарт ажиллагсад 26,2 хувиар тус тус өссөн тоо өссөн байна. 2012 онд нийт ажиллагчдын 80,1 % нь хувийн хэвшилд, 19,7 % нь төрийн байгууллагад, 0,2% нь олон нийт, шашны байгууллагад болон бусад байгууллагад ажиллаж байгаа нь хувийн өмч давамгайлж, хөдөлмөрийн зах зээл сонгодог утгаараа хэрэгжих бас нэг нөхцөл орчин бүрдсэнийг харуулж байна. 2012 оны байдлаар хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг нь аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 42,2 хувийг эзэлж байхад, нийт ажиллагчдын 63,0 хувь нь энэ салбарт ажиллаж байна. Гэтэл аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг ДНБ-ий 6.9 хувийг эзэлж байхад энэ салбарт ажиллагчид нийт ажиллагчдын 3.8 хувийг эзэлж байгаа нь манай аймгийн хувьд мал аж ахуй голлох салбар болхыг харуулж байна.

Зураг 5

**Ажиллагсдын бүтэц / хувиар /**



Зураг 6

**Ажиллагсдын хүйсний бүтэц / 2012 оны байдлаар, салбараар /**





Аймгийн дүнгээр нийт ажиллагчдын 52,7 хувийг эрэгтэйчүүд, 47,3 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг байна.

Эрүүл мэнд, боловсрол, зочид буудал зоогийн газар, нийтийн аж ахуйн, нийгэм хүн амын үйлчилгээ зэрэг байгууллагуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс өндөр байна. Харин уул уурхай, олборлох аж үйлдвэр, цахилгаан, дулааны үйлдвэрлэл, ус хангамж, барилга, төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал, үл хөдлөх хөрөнгө бизнес, түрээсийн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг газруудад эрэгтэйчүүдийн эзлэх хувь нь эмэгтэйчүүдийнхээс харьцангуй өндөр байна.

2012 оны эцэст хөдөлмөр эрхлээгүй хүний тоо Ажиллах Хүчний Судалгааны дүнгээр 11658 болж, 2011 оныхоос 3,7 дахин нэмэгдсэн байна. Энэ нь нэг талаас судалгааны хамрах хүрээ, тухайн үеийн идэвхтэй холбоотой байна. Хөдөлмөр эрхэлж байгаа нийт хүний 39,5 хувьтай тэнцэх хүн 2012 онд хөдөлмөр эрхлээгүй байна. Харин дотоод мэдээлэлээр гарч байгаа тоогоор 8256 хүн ажил эрхлээгүй байна гэсэн тооцоотой байна.

ҮСГ-ын дарга, НХХ-ийн сайдын 2009 оны 01/68/94 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Хүн амын хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүчний тухай үндсэн ойлголт, тодорхойлолт”-ын дагуу хөдөлмөр эрхлээгүй хүн амд хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөлсний болон хувиараа хөдөлмөр эрхэлж цалин, хөлс, орлого олдоггүй, хүндэтгэх ба бусад (хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхолгүй, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлгүй боловч ажил хайж байгаа, тодорхой шалтгаангүй г.м) шалтгаанаар ажил идэвхитэй эрж хайхгүй байгаа хүн амыг хамруулсан. Гэхдээ эдгээрт бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүмүүс ороогүй.

Хүснэгт 13

**Ажил эрхлээгүй хүний тоо /сумаар/**

№	Сумын нэр	2008	2009	2010	2011	2012	өсөлт, бууралт			
							2012 2008	2012 2009	2012 2010	2012 2011
1	Алтай	162	110	95	199	182	112.3	165.5	191.6	91.5
2	Алтанцөгц	332	362	355	304	170	51.2	47.0	47.9	55.9
3	Баяннуур	408	330	486	786	580	142.2	175.8	119.3	73.8
4	Бугат	451	515	373	229	45	10.0	8.7	12.1	19.7
5	Булган	356	230	354	463	109	30.6	47.4	30.8	23.5
6	Буянт	270	120	171	156	166	61.5	138.3	97.1	106.4
7	Дэлүүн	124	200	516	578	535	431.5	267.5	103.7	92.6
8	Ногооннуур	114	49	205	134	178	156.1	363.3	86.8	132.8
9	Сагсай	183	190	296	423	217	118.6	114.2	73.3	51.3
10	Толбо	61	190	68	72	73	119.7	38.4	107.4	101.4
11	Улаанхус	201	514	335	630	69	34.3	13.4	20.6	11.0
12	Цэнгэл	151	109	586	286	218	144.4	200.0	37.2	76.2
13	Өлгий	6043	5465	6694	7961	5554	91.9	101.6	83.0	69.8
14	Цагааннуур	360	350	266	419	160	44.4	45.7	60.2	38.2
<b>Дүн</b>		<b>9216</b>	<b>8734</b>	<b>10800</b>	<b>12640</b>	<b>8256</b>	<b>89.6</b>	<b>94.5</b>	<b>76.4</b>	<b>65.3</b>



Хөдөлмөр эрхлээгүй хүний тоо 2012 онд 2011 оныхоос Буянт, Ногооннуур, Толбо сумдад нэмэгдэж бусад сумуудад харьцангуй буурсан байна. Нийт хөдөлмөр эрхлээгүй хүний 67,3 хувь нь аймгийн төвд амьдарч байна.

Янз бүрийн шалтгаанаар 8256 хүн ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа ба үүнээс хүүхэд, өндөр настан, өвчтэй, өвчтөн асардаг, гэр бүлийн хүний онцлог, гэрийн ажилтай зэрэг тодорхой шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг хасвал 5640 гаруй хүн хүндэтгэх шалтгаангүй тодорхой ажил хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй хүмүүс байна.

Хөдөлмөр эрхлээгүй бүх хүмүүсийг огт ажилгүй гэж үзэх боломжгүй юм. Эдгээр хүмүүсийн дунд их, бага хэмжээгээр хөдөлмөр эрхэлж орлого олдог (гудамж талбайд наймаа хийх, айлд хөлсөөр ажиллах, хүүхэд асрах, улирлын чанартай ажил хийх) хүмүүс байхыг үгүйсгэх аргагүй.

## Хүснэгт 14

## Ажилгүйдлийн түвшин /сумаар/

№	Сумын нэр	2008	2009	2010	2011	2012	өсөлт, бууралт			
							2012 2008	2012 2009	2012 2010	2012 2011
1	Алтай	3.9	2.2	2.8	2.8	2.6	66.1	116.0	91.4	91.7
2	Алтанцөгц	3.5	3.5	5.3	6.0	4.2	120.1	121.2	80.8	70.6
3	Баяннуур	2.0	1.5	1.7	5.5	3.8	195.1	250.4	229.2	69.9
4	Бугат	2.0	2.4	1.6	2.6	1.8	89.6	72.7	112.9	67.2
5	Булган	2.5	2.0	2.4	3.7	2.3	93.6	119.4	96.0	63.4
6	Буянт	2.2	2.7	2.0	2.5	2.0	88.5	71.6	98.1	78.1
7	Дэлүүн	1.5	1.8	2.3	4.0	3.1	208.4	173.5	136.7	78.6
8	Ногооннуур	1.3	1.1	1.8	2.7	2.1	163.3	194.1	117.1	77.4
9	Сагсай	0.9	1.1	2.0	4.3	2.7	297.2	246.8	135.9	63.2
10	Толбо	2.9	1.8	2.3	3.9	2.8	95.9	151.6	119.3	71.9
11	Улаанхус	0.8	0.8	1.2	1.9	1.0	126.0	124.9	82.9	53.5
12	Цэнгэл	1.4	1.4	2.3	2.1	1.7	123.0	120.0	73.1	79.2
13	Өлгий	9.9	11.8	8.5	3.3	6.9	69.0	58.4	80.9	207.3
14	Цагааннуур	9.3	11.3	9.8	10.4	7.7	83.1	68.2	78.7	74.0
	<i>Дун</i>	3.5	3.8	3.7	3.4	3.4	98.2	89.4	92.6	101.5
	Улсын дундаж	2.8	11.5	9.9	10.8	8.2	292.9	71.3	82.8	75.9
	Баруун бүс	3.5	7.5	10.1	7.7	9.8	280.0	130.7	97.0	127.3

Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өмнөх жилүүдээс 0,4 хувиар нэмэгдэж, бүртгэлтэй ажилгүйчүүдээр тооцсон ажилгүйдлийн түвшин нь өмнөх оны хэмжээнд байгаа нь хүснэгт 14-өөс харагдаж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлийн сан бий болгох үүднээс бүртгэл, судалгааг сайжруулах зорилгоор ҮСХ-ны даргын зөвшөөрсөнөөр Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2011 оны 5-р сарын 10-ны өдрийн А/67 тоот тушаалаар батлагдсан Ажил олгочийн бүртгэл, Ажил хайгч иргэний бүртгэл, Ажлын байрны захиалгын мэдээлэл зэрэг маягтын дагуу хөдөлмөрийн зах зээлийн анхан шатны бүртгэлийг шинэчилэн боловсронгуй болгох ажил хийгдсэнээр ажилгүй иргэдийг бүртгэх ажлыг эрчимжүүлж төсөл хөтөлбөрт хамруулан сургах, ажилд

зуучлан оруулах, бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах ажлууд хийгдэж, ажилгүй иргэдийн бүртгүүлэх байдал идэвхиж байгаа нь ажилгүй иргэдийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Улсын дундаж ажилгүйдлийн түвшин нь 8,2 байхад манай аймгийн үзүүлэлт улсынхаас 2,4 дахин, баруун бүсийнхээс 2,9 дахин бага байна.


Хүснэгт 15

**Ажилгүйчүүдийн тоо / 2012 оны байдлаар /**

Сумын нэр	Ажилгүйчүүд		Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажилгүйчүүд		2012 онд ажилд орсон хүн	2012 2011
	2011	2012	2011	2012		
Алтай	59	35	27	16	24	59.3
Алтанцөгц	62	34	40	22	18	54.8
Баяннуур	87	24	34	9	32	27.6
Бугат	34	5	19	3	4	14.7
Булган	69	38	22	13	22	55.1
Буянт	25	15	18	10	8	60.0
Дэлүүн	91	47	26	12	46	51.6
Ногооннуур	70	46	20	15	33	65.7
Сагсай	83	39	32	15	28	47.0
Толбо	65	42	32	20	22	64.6
Улаанхус	55	22	14	5	36	40.0
Цэнгэл	82	49	24	11	25	59.8
Өлгий	214	616	41	33	157	287.9
Цагааннуур	42	30	52	34	6	71.4
Дүн	1038	1042	31	20	461	100.4

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон сумдын засаг даргын тамгын газарт бүртгэлтэй ажил идэвхитэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо 2012 онд 1042 болж 2011 оны жилийн эцсийнхээс 0,4 хувиар буюу 4 хүнээр нэмэгдсэн байна. 2012 оны жилийн эцсийн байдлаар сумуудын бүртгэлтэй ажилгүйчүүдийн хөдөлгөөнийг авч үзвэл 461 бүртгэлтэй ажилгүйчүүд ажилд зуучлагдан орсон байна.


Зураг 7

**Ажилгүйчүүдийн тоо, насны бүлгээр**

2012 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүйдүүдийн 20,0 хувь нь дээд, 4,0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 7,0 хувь нь мэргэжлийн анхан шатны, 63,0 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд, 5,0 хувь нь бага боловсролтой, 1,0 хувь нь боловсролгүй хүмүүс байна (Зураг 8).

Зураг 8

**Бүртгэлтэй ажилгүйдүүдийн боловсролын түвшин / 2012 оны байдлаар /**



Хүснэгт 16


**Шинээр бий болсон ажлын байр / салбараар /**

Салбарын ангилалаар	Шинээр бий болсон ажлын байр бүгд						
	2009 он	2010 он	2011 он	2012 он	Үүнээс:		
					Байнгын	Улирлын чанартай байнгын	ХЭДС-гийн зээлээр бий болсон
Барилга	370	532	575	415	20	395	
Боловсрол	181	194	155	71	71		
Эрүүл мэндийн байгууллага	44	46	36	8	8		
Үйлчилгээний байгууллага	167	159	134	124	117	7	
Боловсруулах үйлдвэр	152	229	259	135	135		
Олборлох үйлдвэр, хайгуул	32	6	72	172	140	32	
Авто засвар, тээвэр, холбоо	13		47	15	15		
Банк санхүүгийн байгууллага	10	6	42	21	21		
Төсвийн байгууллага	66	98	98	16	16		
МАА, газар тариалан	238	390	1049	551	57	360	134
<b>Нийт</b>	<b>1273</b>	<b>1660</b>	<b>2467</b>	<b>1528</b>	<b>600</b>	<b>794</b>	<b>134</b>

Шинэ ажлын байр 2012 онд 1528 болж өнгөрсөн оноос 38,1 хувиар буурсан байна. Энэ ажлын байрны 39,3 хувь нь байнгын ажлын байр, 52,0 хувь нь улирлын

чанартай ажлын байр, 8,8 хувь нь ХЭДС-гийн жижиг зээлээр бий болсон ажлын байр эзэлж байна. Салбараар нь авч үзэхэд шинээр бий болсон ажлын байрны 27,2 хувийг барилгын салбарт, 7,7 хувь нь үйлчилгээний байгууллагад, 8,8 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт, 4,6 хувийг боловсролын байгууллагад бий болсон ажлын байр эзэлж байна.

Зураг 9

**Шинэ ажлын байрны бүтэц 2012 он**

Засгийн газрын зүгээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ хууль эрх зүйн болон бусад таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч, Улсын Их Хурлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг баталж, 2001 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдөж байна. Энэ хуулийн гол агуулга нь сургалт, зөвлөлгөө, мэдээллээр хангах, мэргэжлийн сургалт, давтан сургалт явуулах, хувийн аж ахуй эрхлэлт, хоршоодыг дэмжих, ажил олгогч нарыг дэмжих, нийтийг хамарсан түр хугацааны хөдөлмөр эрхлэх ажлыг зохион байгуулах зэрэгт чиглэж байна. Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын байгууллагаас олгох зээл, тусламж, хандив, бусад эх үүсвэрүүдээс бүрдэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг дээрх хуулийн дагуу байгуулан зарцуулж байна.

Хүснэгт 17

**Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан хөрөнгө**

Д/Д Сангийн зарлагын зориулалт	Зарцуулсан хөрөнгө / мян төг/							
	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Иргэдэд ажил мэргэжлээ								
1 сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	21589.3	26684.5	30128.0	34713.2	58800.0	11228.1	85233.1	7738.7
2 Ажилд зуучлах	4540.3	4258.8	7325.8	6616.1	8008.1	10198.2	8932.5	2182.4
3 Нийтийг хамарсан ажил	42897.3	56867.9	40125.5	65445.9	139445.8	132724.7	206485.6	131359.7
4 Ажил олгогчийг дэмжигчийн үйлчилгээний арга хэмжээ	6928.3	9939.4	23083.5	32331.8	48226.7	29588.6	213356.7	24757.8
5 Зээлийн хүүгийн нөхөн төлбөр							11357.0	1792.5
<b>Дүн</b>	<b>75955.2</b>	<b>97750.6</b>	<b>100662.8</b>	<b>139107.0</b>	<b>254480.6</b>	<b>183739.6</b>	<b>525364.9</b>	<b>167831.1</b>

Хөдөлмөр эрхлэлтийн санд улсын төсвийн орлогоос 0,3 хувь хүртэлх хөрөнгийг оруулах ёстой бөгөөд тус аймагт 2005 онд 75.9 сая төгрөг, 2008 онд 139.1 сая төгрөг, 2010 онд 183.7 сая төгрөг, 2011 онд 525,3 сая төгрөг, 2012 онд 167,8 сая төгрөг зарцуулсан байна. Үүний үр дүнд 2011 онд 6248 хүнд ХЭДС-гаас үйлчилгээ үзүүлж байсан бол энэ онд 6248 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын эрх зүйн таатай орчин бүрдэж эхэлсний үр дүнд 650 хүнийг мэргэжил олгох дамжаанд хамруулж 7,7 сая төгрөг, 403 хүнийг янз бүрийн ажилд зуучлан оруулж 2,1 сая төгрөг, нийтийг хамарсан ажилд 890 хүн хамруулж 131,3 сая төгрөг хувиарлагдан олгогдсон байна.

## Хүснэгт 18

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар үйлчлүүлсэн хүний тоо

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	Хамрагдсан хүний тоо							
		2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
	Иргэдэд ажил мэргэжлээ								
1	сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	548	242	674	465	822	1100	2999	650
2	Ажилд зуучлах	1340	453	1658	1552	1560	888	1581	403
3	Нийтийг хамарсан ажил	534	1460	750	760	1519	1291	1525	890
4	Ажил олгогчийг дэмжигчийн үйлчилгээний арга хэмжээ	60	39	66	68	94	48	143	32
5	Зээлийн хүүгийн нөхөн төлбөр							119	19
	<b>Дүн</b>	<b>2482</b>	<b>2194</b>	<b>3148</b>	<b>2845</b>	<b>3995</b>	<b>3327</b>	<b>6248</b>	<b>1975</b>

Д/Д	Сангийн зарлагын зориулалт	Нэг хүнд ноогдох / мян төг /							
		2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012
	Иргэдэд ажил мэргэжлээ								
1	сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	39.4	110.3	44.7	74.7	71.5	10.2	28.4	11.9
2	Ажилд зуучлах	3.4	9.4	4.4	4.3	5.1	11.5	5.6	5.4
3	Нийтийг хамарсан ажил	80.3	39.0	53.5	86.1	91.8	102.8	135.4	147.6
4	Ажил олгогчийг дэмжих	115.5	254.9	349.8	475.5	513.1	616.4	1492.0	773.7
	<b>Дүн</b>	<b>30.6</b>	<b>44.6</b>	<b>32.0</b>	<b>48.9</b>	<b>63.7</b>	<b>55.2</b>	<b>84.1</b>	<b>85.0</b>

Дээрхи сангийн зарцуулалтаас үзэхэд хамрагдсан нэг хүнд мэргэжил олгох сургалтанд зориулж 11,9 мян төгрөг, нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүмүүст зориулж 147,6 мянган төгрөг, ажил олгогчийг дэмжиж урамшуулахад 773,7 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

### Дүгнэлт

1. Хөдөлмөрийн насны хүн амын тоо нийт хүн амын тооноос илүү хурдацтай өсч ирсэн нь хүн амын ажил эрхлэлтийг дээшлүүлэх, ажилгүйдлийг бууруулахад онцгой анхаарч ажиллах шаардлага бий болсныг харуулж байна.
2. Манай аймаг 2011 онд ажиллах хүчнийхээ 96,6 хувийг ашиглаж байсан бол 2012 онд мөн 96,6 хувийг ашиглаж өмнөх жилийн түвшинд байна.
3. Сүүлийн жилүүдэд уул уурхай, боловсруулах үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, үйлчилгээ бизнесийн бусад салбарт ажил эрхлэгчдийн тоо нэмэгдэж байна.
4. Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 42,2 хувийг эзэлж, нийт ажиллагчдын 62,6 хувь нь энэ салбарт ажиллаж байна. Энэ нь манай аймгийн хувьд голлох салбар нь мал аж ахуй болохоо харуулж байна.
5. Хөдөлмөрийн насны суралцагчдын 45,5 хувь нь эрэгтэйчүүд, 54,5 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба хувийн жингээрээ эмэгтэйчүүд нь давамгайлж байна.
6. Нийт хөдөлмөр эрхлээгүй хүн амын 67,3 хувь нь аймгийн төвд амьдарч байгаа нь нэг талаас иргэд сургуулийн насны хүүхдийг сургуульд сургах, нөгөө талаас ажил хийх сонирхолтой хүмүүс төв суурин газарт илүү төвлөрч байна.
7. Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн 54,4 хувь нь 16-34 насны залуучууд байна.
8. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн гурван хүний нэг нь дээд болон мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байгаа ба залуучуудад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах нөхцөлийг бүрдүүлж зуучлах байгууллагуудтай хамтран ажил зохиох.
9. Ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа, нийгмийн эмзэг бүлгийн иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэд болон тухайн онд ЕБС-ийн 9,11 дүгээр анги төгссөн ажил, сургуульгүй үлдсэн хүүхдүүдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажлын байртай мэргэжил олгох болон мэргэшлийн ур чадварын сургалтанд илүү хамруулахын зэрэгцээ сургалтын чанарыг сайжруулаж, үр дүнгийн явц байдлыг аймгийн удирдлагын зүгээс хянаж байх тогтолцоог бүрдүүлэх.

### Ашигласан ном, материалууд

1. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2008, 2009, 2010, 2011 он
2. Хүн амын ажил эрхлэлтийн дотоод мэдээлэл 2009, 2010, 2011, 2012 он
3. Баян-Өлгий аймгийн эдийн засаг нийгмийн байдлын статистикийн эмхтгэл 2011, 2012 он
4. Хөдөлмөр эрхлэлтийн албаны 2010, 2011, 2012 оны ажлын тайлан
5. Ажиллах хүчний судалгааны 2012 оны үр дүнгийн тайлан